

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/02/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: [tsaranchimeg@audit.gov.mn](mailto:tsaranchimeg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.4 Зөвлөмж .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОБГ	Онцгой байдлын газар
АОК	Аймгийн Онцгой комисс
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.22 № 01/45  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА Н.ТӨМӨРБААТАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ  
19020213

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгсгөрөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>565,782,481.37</b>	<b>415,827,014.35</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	565,782,481.37	415,827,014.35
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	388,483,174.95	344,185,240.03
35110	Тусгай зориулалттай материал	388,418,674.95	344,120,740.03
35130	Эм боох материал	64,500.00	64,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	94,160,946.10	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	82,288,360.32	70,791,774.32
35410	Бичиг хэргийн материал	1,545,770.00	1,914,870.00
35420	Аж ахуйн материал	65,875,078.32	65,875,078.32
35440	Түлш, шатах тослох материал	1,429,612.00	1,715,926.00
35470	Бусад хангамжийн материал	13,437,900.00	1,285,900.00
35600	Мал амьтад	850,000.00	850,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,518,003,024.31</b>	<b>6,307,493,361.96</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,518,003,024.31	6,307,493,361.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,885,469,024.31	5,674,959,361.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,738,557,192.40	3,857,582,036.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-287,272,105.59	-408,463,537.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,912,468,371.00	2,986,570,471.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-743,738,011.17	-1,030,326,861.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	366,259,630.91	392,688,539.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-174,167,533.82	-228,316,929.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,838,250.60	40,734,691.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,978,693.98	-23,843,958.30
39209	Зам, гүүрийн байгууламж	87,738,979.00	134,207,853.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-31,237,055.04	-45,872,942.84
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	632,534,000.00	632,534,000.00
39301	Програм хангамж	3,971,975.00	3,971,975.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,971,975.00	-3,971,975.00
39303	Бусад биет бус хөрөнгө	632,534,000.00	632,534,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,083,785,505.68</b>	<b>6,723,320,376.31</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,083,785,505.68</b>	<b>6,723,320,376.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,083,785,505.68	6,723,320,376.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	1,307,549,861.72	1,307,549,861.72
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,996,352,740.83	4,635,887,611.46
51210	Өмнөх үеийн үр дүн	3,996,352,740.83	3,996,352,740.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	639,534,870.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	779,882,903.13	779,882,903.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,083,785,505.68</b>	<b>6,723,320,376.31</b>

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,916,845,615.00</b>	<b>3,757,747,664.76</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>595,890,467.00</b>	<b>1,352,218,966.76</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	595,890,467.00	1,352,218,966.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	595,890,467.00	1,352,218,966.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	595,890,467.00	1,352,218,966.76
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,320,955,148.00</b>	<b>2,405,528,698.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,048,872,000.00	2,043,289,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,048,872,000.00	2,043,289,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	272,083,148.00	362,239,298.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	110,562,770.00	85,430,279.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	54,206,618.00	229,470,669.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	107,285,760.00	45,088,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	28,000.00	2,250,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,122,005,192.37</b>	<b>3,118,212,794.13</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,122,005,192.37</b>	<b>3,118,212,794.13</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,010,033,713.37	2,998,383,603.13
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,428,771,565.00	1,320,416,551.00
210101	Үндсэн цалин	984,853,488.00	750,029,397.00
210102	Нэмэгдэл	391,461,577.00	523,069,654.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,456,500.00	47,317,500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,474,031.00	46,754,414.00
210201	Тэтгэврийн даатгал	17,976,916.00	17,336,828.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,114,929.00	1,921,465.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,648,905.00	1,510,293.00
210204	Ажилгүйдлийн даатгал	389,412.00	321,258.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,343,869.00	25,664,570.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	224,902,636.00	225,290,624.00
210301	Гэрэл, цахилгаан	14,264,913.00	18,319,035.00
210302	Түлш, халаалт	204,708,415.00	197,943,581.00
210303	Цэвэр, бохир ус	5,929,308.00	9,028,008.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	214,415,699.97	204,932,314.54
210401	Бичиг хэрэг	10,820,850.00	19,578,691.82
210402	Тээвэр, шатахуун	90,083,680.00	100,838,752.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,876,273.00	2,949,122.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,914,896.97	80,845,748.72
2105	<b>Нормативт зардал</b>	259,814,463.20	354,643,506.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,874,700.00	16,225,300.00
210502	Хоол, хүнс	67,638,400.00	137,600,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	175,301,363.20	200,818,016.31
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,449,520.00	74,913,190.00
210604	Урсгал засвар	7,449,520.00	74,913,190.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	38,855,500.00	65,852,100.00
210702	Дотоод албан томилолт	38,855,500.00	65,852,100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	12,059,491.00	22,079,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	00.00	10,812,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,168,000.00	1,264,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,720,600.00	5,720,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,480,464.00	1,518,094.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	649,000.00	748,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	462,000.00	561,000.00
210807	Газрын төлбөр	2,579,427.00	1,454,722.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	773,290,807.20	683,501,637.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	319,539,473.00	203,070,807.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	453,751,334.20	480,430,830.28
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	111,971,479.00	119,829,191.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	78,960,000.00	19,940,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	01.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,960,000.00	19,940,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	33,011,479.00	99,889,191.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,011,479.00	99,889,191.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-205,159,577.37</b>	<b>639,534,870.63</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-205,159,577.37</b>	<b>639,534,870.63</b>

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,307,549,861.72	779,882,903.13	4,218,324,123.40	00.00	6,305,756,888.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,307,549,861.72</b>	<b>779,882,903.13</b>	<b>4,218,324,123.40</b>	<b>00.00</b>	6,305,756,888.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-221,971,382.57	00.00	-221,971,382.57
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,307,549,861.72</b>	<b>779,882,903.13</b>	<b>3,996,352,740.83</b>	<b>00.00</b>	6,083,785,505.68
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,307,549,861.72</b>	<b>779,882,903.13</b>	<b>3,996,352,740.83</b>	<b>00.00</b>	6,083,785,505.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,307,549,861.72</b>	<b>779,882,903.13</b>	<b>3,996,352,740.83</b>	<b>00.00</b>	6,083,785,505.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	639,534,870.63	00.00	639,534,870.63
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,307,549,861.72</b>	<b>779,882,903.13</b>	<b>4,635,887,611.46</b>	<b>00.00</b>	6,723,320,376.31

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,320,955,148.00</b>	<b>2,405,528,698.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,320,955,148.00</b>	<b>2,405,528,698.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,048,872,000.00	2,043,289,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,048,872,000.00	2,043,289,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	272,083,148.00	362,239,298.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	110,562,770.00	85,430,279.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	54,206,618.00	229,470,669.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	107,285,760.00	45,088,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	28,000.00	2,250,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,358,955,148.00</b>	<b>2,405,528,698.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,358,955,148.00</b>	<b>2,405,528,698.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,255,901,169.00</b>	<b>2,285,699,507.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,428,771,566.00	1,320,416,551.00
210101	Үндсэн цалин	962,751,922.00	750,029,397.00
210102	Нэмэгдэл	413,563,144.00	523,069,654.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,456,500.00	47,317,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,474,030.00	46,754,414.00
210201	Тэтгэврийн даатгал	17,976,916.00	17,336,828.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,114,929.00	1,921,465.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,648,905.00	1,510,293.00
210204	Ажилгүйдлийн даатгал	389,412.00	321,258.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,343,868.00	25,664,570.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	224,902,636.00	225,290,624.00
210301	Гэрэл, цахилгаан	14,264,913.00	18,319,035.00
210302	Түлш, халаалт	204,708,415.00	197,943,581.00
210303	Цэвэр, бохир ус	5,929,308.00	9,028,008.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	101,371,983.00	70,629,313.00
210401	Бичиг хэрэг	3,322,200.00	3,814,200.00
210402	Тэвэр, шатахуун	92,542,980.00	60,389,141.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,499,203.00	3,418,372.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,287,600.00	2,287,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	61,170,000.00	109,651,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	704,700.00	11,304,700.00
210502	Хоол, хүнс	60,112,000.00	98,346,830.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	353,300.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	139,349,620.00	228,189,892.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,150,900.00	20,648,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	570,200.00	00.00
210604	Урсгал засвар	43,628,520.00	207,541,892.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	31,223,500.00	65,852,100.00
210702	Дотоод албан томилот	31,223,500.00	65,852,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	12,059,491.00	26,479,576.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	00.00	15,213,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,168,000.00	1,264,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,720,600.00	5,720,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,480,464.00	1,518,094.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	649,000.00	748,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	462,000.00	561,000.00
210807	Газрын төлбөр	2,579,427.00	1,454,722.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	206,578,343.00	192,435,507.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	203,572,343.00	185,057,507.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,006,000.00	7,378,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>103,053,979.00</b>	<b>119,829,191.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	70,042,500.00	19,940,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,042,500.00	19,940,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	33,011,479.00	99,889,191.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-38,000,000.00</b>	<b>00.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-38,000,000.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	38,000,000.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,048,872,000.00	2,015,860,521.00	2,043,289,400.00	1,957,336,839.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,048,872,000.00	2,015,860,521.00	2,043,289,400.00	1,957,336,839.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,044,572,000.00	2,011,560,521.00	2,037,997,500.00	1,952,046,839.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,429,659,200.00	1,428,771,566.00	1,389,191,100.00	1,320,416,551.00
210101	Үндсэн цалин	977,394,200.00	962,751,922.00	753,530,400.00	750,029,397.00
210102	Нэмэгдэл	443,952,000.00	413,563,144.00	589,922,700.00	523,069,654.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,313,000.00	52,456,500.00	45,738,000.00	47,317,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,912,400.00	50,474,030.00	56,042,800.00	46,754,414.00
210201	Тэтгэврийн даатгал	21,274,200.00	17,976,916.00	18,955,900.00	17,336,828.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,239,400.00	2,114,929.00	1,759,500.00	1,921,465.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,791,500.00	1,648,905.00	1,407,600.00	1,510,293.00
210204	Ажилгүйдлийн даатгал	447,900.00	389,412.00	351,900.00	321,258.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,159,400.00	28,343,868.00	33,567,900.00	25,664,570.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	241,171,900.00	224,902,636.00	229,971,900.00	224,595,624.00
210301	Гэрэл, цахилгаан	14,384,800.00	14,264,913.00	20,184,800.00	18,319,035.00
210302	Түлш, халаалт	222,170,200.00	204,708,415.00	183,170,200.00	197,248,581.00
210303	Цэвэр, бохир ус	4,616,900.00	5,929,308.00	26,616,900.00	9,028,008.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	87,569,200.00	86,610,403.00	42,628,000.00	41,372,332.00
210401	Бичиг хэрэг	3,294,200.00	3,294,200.00	3,294,200.00	3,294,200.00
210402	Тээвэр, шатахуун	77,809,400.00	77,809,400.00	32,868,200.00	32,868,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,458,000.00	2,499,203.00	3,458,000.00	2,202,332.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	720,000.00	720,000.00	720,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,287,600.00	2,287,600.00	2,287,600.00	2,287,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	60,810,000.00	60,810,000.00	61,376,700.00	61,376,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	704,700.00	704,700.00	704,700.00	704,700.00
210502	Хоол, хүнс	59,752,000.00	59,752,000.00	60,672,000.00	60,672,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	353,300.00	353,300.00	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	139,349,700.00	139,349,620.00	225,939,900.00	225,939,892.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,150,900.00	95,150,900.00	20,648,000.00	20,648,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	570,200.00	570,200.00	00.00	00.00
210604	Урсгал засвар	43,628,600.00	43,628,520.00	205,291,900.00	205,291,892.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	1,246,600.00	1,246,000.00	1,246,600.00	1,246,600.00
210702	Дотоод албан томилолт	1,246,600.00	1,246,000.00	1,246,600.00	1,246,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	17,020,600.00	12,059,491.00	24,222,500.00	22,966,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	00.00	00.00	11,701,900.00	11,700,310.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,600,000.00	1,168,000.00	1,600,000.00	1,264,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,720,600.00	5,720,600.00	5,720,600.00	5,720,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,750,000.00	1,480,464.00	1,750,000.00	1,518,094.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	750,000.00	649,000.00	750,000.00	748,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	462,000.00	600,000.00	561,000.00
210807	Газрын төлбөр	6,600,000.00	2,579,427.00	2,100,000.00	1,454,722.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7832400.00	7336775.00	7378000.00	7378000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,826,300.00	4,330,775.00	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,006,100.00	3,006,000.00	7,378,000.00	7,378,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4300000.00	4300000.00	5291900.00	5290000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,300,000.00	4,300,000.00	5,291,900.00	5,290,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	4,300,000.00	5,291,900.00	5,290,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,048,872,100.00	2,015,860,521.00	2,043,289,400.00	1,957,336,839.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,048,872,100.00	2,015,860,521.00	2,043,289,400.00	1,957,336,839.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,048,872,100.00	2,015,860,521.00	2,043,289,400.00	1,957,336,839.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	38,000,000.00	00.00	00.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	132	113	132	97
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	107	88	107	72
620003	Үйлчлэх ажилтан	24	24	24	24

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>272,083,148.00</b>	<b>362,239,298.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>272,083,148.00</b>	<b>362,239,298.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	206,340,648.00	347,589,298.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	695,000.00
210302	Түлш, халаалт	00.00	695,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,761,580.00	29,256,981.00
210401	Бичиг хэрэг	28,000.00	520,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,733,580.00	27,520,941.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,216,040.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	360,000.00	48,274,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	10,600,000.00
210502	Хоол, хүнс	360,000.00	37,674,830.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	2,250,000.00
210604	Урсгал засвар	00.00	2,250,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	29,977,500.00	64,605,500.00
210702	Дотоод албан томилолт	29,977,500.00	64,605,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	3,512,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,512,850.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	161,241,568.00	185,057,507.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,241,568.00	185,057,507.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	65,742,500.00	14,650,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	65,742,500.00	14,650,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	65,742,500.00	14,650,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>13,936,630.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>272,083,148.00</b>	<b>362,239,298.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	272,083,148.00	362,239,298.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	110,562,770.00	85,430,279.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,206,618.00	229,470,669.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,285,760.00	45,088,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,000.00	2,250,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох ө баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 33/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Онцгой байдлын газар нь Монгол Улсын хүн ам, мал амьтад, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлийг болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх замаар Монгол хүний аюулгүй амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх эрхэм зорилготой.

Төв аймгийн Онцгой байдлын газар нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, унтраах, авран хамгаалах, эрэн хайх аврах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Онцгой байдлын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж,

гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь хэлтэс, тасаг, хэсгүүдэд 11 үзүүлэлтээр дотоод хяналт хийх төлөвлөгөө гаргасны дагуу шалгалт хийж, шалгалтын дүнг хэлэлцүүлэн илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газраас болон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос 1,5 хувиар буюу 43,752.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 32,814.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос 1,5 хувиар буюу 56,366.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 42,274.7 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 12,613.5 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Онцгой байдлын ерөнхий газрын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккреул сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### ***Орлого:***

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 2,043,289.4 мянган төгрөг, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажилд иргэн, аж ахуй нэгжүүдээс өгсөн хандив 85,430.3 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын Тамгын газраас ковидоос урьдчилан сэргийлэх болон тусгаарлах байр, шуурхай штаб, эргүүл постын зардлын санхүүжилт 229,470.7 мянган төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас 45,088.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,352,219.0 мянган төгрөг нийт 3,757,747.7 мянган төгрөг, өмнөх оноос 775,902.1 мянган төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн байна.

#### ***Зардал:***

Төв аймгийн Онцгой байдлын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,118,212.8 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 2,405,528.7 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,957,336.8 мянган төгрөг зарцуулсан байна.

#### ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:***

Тус байгууллага төрийн сангийн 100140031001 тоот дансанд 2021 онд 2,043,289.4 мянган төгрөгийн орлого, 2,043,289.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140031401 тоот дансанд 362,239.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 362,239.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	565,782.5	415,827.0	(149,955.5)
Үндсэн хөрөнгө	5,518,003.0	6,307,493.4	789,490.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,083,785.5</b>	<b>6,723,320.4</b>	<b>639,534.9</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,083,785.5	6,723,320.4	639,534.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,083,785.5</b>	<b>6,723,320.4</b>	<b>639,534.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 415,827.0 мянган төгрөг болж 149,955.5 мянган төгрөгөөр буурсан нь бэлэн бүтээгдэхүүн /нормын хувцас/ 94,160.9 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын материал 44,298.0 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 12,152.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,307,493.4 мянган төгрөг болж 789,490.4 мянган төгрөгөөр өссөн нь Онцгой байдлын ерөнхий газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас тусгай тоноглолтой автомашин, тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийн дансанд 1,083,779.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 176,941.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,083,779.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд хөрөнгийн зарлага гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,723,320.4 мянган төгрөг болж 639,534.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,143,264.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,143,264.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 87,474.7 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 2,055,789.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан

байна. Энэ нь цалингийн зардлыг 143,107.0 мянган төгрөгөөр зардлыг бууруулсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,043,289.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,043,289.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,043,289.4 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,957,336.8 мянган төгрөгийг зарцуулж, 85,952.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,957,336.8 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 79,141.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Онцгой байдлын газар нь тайлант онд Онцгой байдлын ерөнхий газраас 45,088.4 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар 229,470.7 мянган төгрөг, иргэд, аж ахуйн нэгжээс хандив 85,430.3 мянган төгрөг, даатгалын нөхөн төлбөр 2,250.0 мянган төгрөг нийт 362,239.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр, шатахууны зардалд 27,520.9 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл 10,600.0 мянган төгрөг, хоол, хүнсний материалд 37,674.8 мянган төгрөг, томилолтын зардалд 64,605.5 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 185,057.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 14,650.0 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 13,936.6 мянган төгрөг нийт 362,239.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

2021 онд Ковидтой тэмцэх үйл ажиллагааны хүрээнд 22 ААНБ, байгууллагаас 78,545.0 мянган төгрөг, 2 иргэнээс 700.0 мянган төгрөг, 2020 оны ААНБ, иргэдийн хандивын үлдэгдэл 6,185.3 мянган төгрөг нийт 85,430.3 мянган төгрөгийн хандивыг 100140031401 тоот дансанд орлого авсан байна. Мөн 12 ААНБ, иргэдээс 23,830.4 төгрөгийн эд материал ирүүлснийг тухайн хандивлагчаас худалдан авсан үнийг тухай

бүр асууж данс бүртгэлд орлогод авч Шилэн дансанд байршуулж аймгийн Онцгой комисс болон шуурхай штабаас гарсан шийдвэрийн дагуу зарцуулж ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-аас Аймгийн Засаг даргын 22 удаагийн захирамжаар 229,470.7 мянган төгрөг 100140031401 тоот дансанд орж ирснийг Ковидын хөл хорио тогтоох цэгүүдэд ажилласан алба хаагчид, нэг өрх нэг шинжилгээ, иргэдийг вакцинжуулах ажлыг зохион байгуулсан төрийн алба хаагчид, тусгаарлах байранд ажиллаж байгаа алба хаагчдын хоол, томилолт, шатахууны зардал, сумдад тусламж хүргэх шатахуун, тээврийн зардал болон тусгаарлагдсан иргэдийн хоол хүнс, бусад хэрэглээний зардалд захирамжийн дагуу зарцуулж ажилласан байна.

Дээрх хандив болон Аймгийн Засаг даргын захирамжаар санхүүжүүлсэн хөрөнгийг зарцуулахдаа Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 45 дугаар тогтоолын дагуу Гамшгийн үеийн улаан түвшинд худалдан авалтыг Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/101 тоот Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг зохион байгуулах салбар хороодыг томилох тухай захирамжийн дагуу зохион байгуулж ажилласан байна. Үүнд: Иргэдээс шинжилгээ авах, вакцинд хамруулахад ажилласан алба хаагчдын хоолны болон тусгаарлах байранд тусгаарлагдсан иргэдийн хоол бусад зардалд 30,886.0 мянган төгрөг, халдвар хамгааллын хувцас хэрэглэлд 58,939.5 мянган төгрөг, хорио цээрийн постод болон шуурхай штабт үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдыг хоолонд 35,117.9 мянган төгрөг, ОБГ-ын алба хаагчдын томилолтод 20,316.0 мянган төгрөг, шатахуунд 27,520.9 мянган төгрөг, явуулын байрт 16,584.0 мянган төгрөг, хүнс витамин багцад 45,490.0 мянган төгрөг, АОК болон шуурхай штабын шуудан холбоо, бичиг хэрэг зэрэг бусад зардалд 13,699.8 мянган төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн байна.

Аргалант, Баян, Баянцагаан, Зуунмод, Сэргэлэн сумдын ЗДТГ, аймгийн ЭМГ, МХГ, МЭГ, Төв Чандмань ДЭХГ, Цагдаагийн газарт нийт 52,590.1 мянган төгрөгийг дансаар шилжүүлсэн бөгөөд үлдэгдэл 13,936.6 мянган төгрөгийг АЗДТГ-ын 100140051499 тоот дансанд татан төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн Онцгой байдлын газар нь 27 сумын ЗДТГ, 4 сумын Эрүүл мэндийн төв болон аймгийн төвийн 38 ААНБ-д 122,356.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгч анхан шатны баримтыг бүрдүүлэн тооцоо нийлж ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Ковидоос урьдчилан сэргийлэх зардал, тусгаарлах байрны зардал, шуурхай штабын зардал, постын хяналтын зардал, нэг өрх нэг шинжилгээ, иргэдийг вакцинжуулах зардалд нийт 351,051.4 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалын зардал гарсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Тус байгууллага Шилэн дансанд хөрөнгө худалдан авах тухай гэрээнүүдийг байршуулсан, 5,000.0 мянган төгрөгөөс дээших зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Онцгой байдлын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 362,239.3 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлэх, үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, орлого бууруулахгүйгээр мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед бүртгэхтэй холбоотой 4 зөвлөмжийг 100.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Онцгой байдлын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 33/94 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрэн хайх аврах салбар, Гал түймэр унтраах аврах 24-р анги, Мөнгөнморьт сум дахь Гал түймэр унтраах аврах 75-р анги, Баян сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Лүн сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Зуунмод сум дахь Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн анги салбарт бүртгэлтэй хөрөнгийг тоолох

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 70,179.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 59,842.9 мянган төгрөгийн алдааг залруулж, дотоод хяналтын болон бусад зөрчилд 10,337.1 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

#### 4.1 Залруулсан алдаа

Мөнгөнморьт сумын ЗДТГ-т бүртгэлтэй тус байгууллагын салбар анги байрлах оффисын барилгын их засвар, шинээр баригдсан автограшийн барилгын 59,842.9 мянган төгрөгийн зардлыг данс бүртгэлд аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайлангийн зарцуулалтыг шалгахад 9,450.0 мянган төгрөгийн хүнсний багцыг 27 суманд жагсаалтаар тараасан бөгөөд гүйцэтгэлийг авч тайлагнаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Үнэ төлбөргүй олгосон бараа материалын зардлын зарцуулалтыг жагсаалтаар тараасан ч холбогдогч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулж байх

## **2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Анги салбарууд дээр үүрэг гүйцэтгэж буй авто машины шатахууны үлдэгдлийн тооцоог шалгахад автомашины шатахууны саванд байгаа үлдэгдэл 887.1 мянган төгрөгөөр илүү үлдэгдэлтэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Тусгай зориулалтын автомашин техник, зэвсэглэмжийн өдөр тутмын бэлтгэл бэлэн байдал хангах шатахуун, тосны зарцуулалтыг тооцох журмын дагуу авто машины шатахууны саван дахь / банкны/ үлдэгдлийг тооцож, бүрэн тайлагнаж байх

## **3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

### **3.1. Илрүүлэлт:**

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд дотоод хяналтын шалгалт хийгдээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1-д “Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна”, 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” хийх гэсэн чиглэлийн дагуу Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд бүртгэлээр тавих хяналт шалгалт руу чиглүүлэн үр дүнг, тооцож ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Онцгой байдлын газар	4	70,179.9	1	59,842.9	0	0	0	0	3	10,337.1